



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэмандал сумын “Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц”  
ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/04-НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.Open.audit.mn](http://www.Open.audit.mn)  
Архангай аймаг  
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)  
Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerguibaatard@audit.gov.mn](mailto:Nerguibaatard@audit.gov.mn)  
Ахлах аудитор П.Цэцэгдулам  
Утас: 7033-3019  
Цахим хаяг: [Tsetsegdulam@audit.gov.mn](mailto:Tsetsegdulam@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн батлагдсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл .....	7
5. Аудитын илрүүлэлт .....	8
<b>5.1 Албан шаардлага</b> .....	8
5.2 Зөвлөмж .....	8
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	10

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

## 1. Аудитын санал дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhantai@audit.gov.mn

2024.03.15 № 145  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭМАНДАЛ ХӨГЖЛИЙН  
ДЭД БҮТЭЦ ОНӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Ц.ЛОМБО ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Тайлант онд 64,507.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авахгүйгээр худалдан авч бэлтгэсэн.
2. Тус байгууллагаас хэрэглэгчдэд дулааны эрчим хүчээр хангах үйлчилгээний үнэ тарифыг эрх байгууллагаар батлуулаагүй байна.
3. Тус газрын ТУЗ нь 2023 оны бизнес төлөвлөгөөг батлаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Эрчим хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, ОНӨААТҮГ-ын дүрмийн 5.3, 6.7.3, 6.7.6 дахь заалтыг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр, аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	24,708,960.82	63,019,226.83
1.1.2	Дансны авлага	2,520,000.00	-
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,363,117.00	<b>150,000.00</b>
1.1.4	Бусад авлага	8,000,000.00	-
1.1.6	Бараа материал	18,441,249.00	7,011,299.00
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>55,033,326.82</b>	<b>70,180,525.83</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	101,273,337.00	153,214,957.00
1.2.2	Биет бус хөрөнгө		2,442,000.00
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>101,273,337.00</b>	<b>155,656,957.00</b>
<b>1.30</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>156,306,663.82</b>	<b>225,837,482.83</b>
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>8,654,446.21</b>	<b>9,356,090.12</b>
2.1.1.3	Татварын өр	8,654,446.21	7,754,490.12
2.1.1.5	НӨАТ-ын өглөг	-	1,601,600.00
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,654,446.21</b>	<b>9,356,090.12</b>
<b>2.20</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,654,446.21</b>	<b>9,356,090.12</b>
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	68,844,000.00	68,844,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	78,808,217.61	147,637,392.71
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>147,652,217.61</b>	<b>216,481,392.71</b>
<b>2.40</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>156,306,663.82</b>	<b>225,837,482.83</b>

### 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	391,184,048.10	462,361,477.27
2	Борлуулалтын өртөг	179,560,796.00	279,573,816.05
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>211,623,252.10</b>	<b>182,787,661.22</b>
8	Бусад орлого		37,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	124,078,790.00	143,310,800.00
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>87,544,462.10</b>	<b>76,476,861.22</b>
19	Орлогын татварын зардал	8,754,446.21	<b>7,647,686.12</b>
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>78,790,015.89</b>	<b>68,829,175.10</b>
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>78,790,015.89</b>	<b>68,829,175.10</b>
24	Орлогын нийт дүн	<b>78,790,015.89</b>	<b>68,829,175.10</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	68,844,000.00	78,808,217.61	147,652,217.61
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<b>68,844,000.00</b>	<b>78,808,217.61</b>	<b>147,652,217.61</b>
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		68,829,175.10	68,829,175.10
17	2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	<b>68,844,000.00</b>	<b>147,637,392.71</b>	<b>216,481,392.71</b>

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	403,913,950.10	556,117,625.27
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	399,338,195.10	511,117,625.27
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	37,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,575,755.00	8,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	330,303,391.00	451,650,359.26
1.2.1	Ажиллагчдад төлсөн	66,251,563.00	74,828,448.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	17,477,366.00	20,697,795.95
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	18,362,869.00	12,002,300.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	45,537,316.00	52,867,300.45
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	162,275,665.00	227,954,539.03
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	13,881,857.00	63,161,275.78
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,516,755.00	138,700.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	73,610,559.10	104,467,266.01
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	48,919,800.00	66,157,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,599,800.00	64,507,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,320,000.00	1,650,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	8,000,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(48,919,800.00)	(66,157,000.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	24,690,759.10	38,310,266.01
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,201.72	24,708,960.82
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,708,960.82	63,019,226.83

**2.5 Аудит хийсэн батлагдсан зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл**

/төгрөгөөр/

№	Зардлын ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Цалин	100,777.1	88,760.3	12,016.8
2	НДШ 12.5%	12,597.1	10,115.8	<b>2,481.3</b>
4	Гэрэл цахилгаан	63,000.0	51,778.3	11,221.7
5	түлээ, нүүрс	190,400.0	184,945.7	<b>5,454.3</b>
6	Цэвэр бохир ус	1,800.0	1,780.0	<b>20.0</b>
7	Бичиг хэрэг	1,000.0	789.0	211.0
8	Тээвэр шатахуун	8,000.0	7,287.6	712.4
9	Мэдээлэл технологи	2,800.0	2,020.0	780.0
10	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	650.0	641.0	<b>9.0</b>
11	Дотоод албан томилолт	5,600.0	2,540.0	3,060.0
12	Аудитын хөлс	1,500.0	1,500.0	-
13	Шуудан холбоо	650.0	485.0	165.0
14	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	6,000.0	1,886.4	4,113.6
15	Нормын хувцас	3,000.0	2,874.2	<b>125.8</b>
16	Хичээл сургалт	4,000.0	2,770.0	1,230.0
17	Шаардлагатай тоног төхөөрөмж	82,370.0	74,123.6	<b>8,246.4</b>
18	Бараа үйлчилгээний бусад зардал	41,715.7	41,686.0	<b>29.7</b>
19	Урсгал засвар	43,830.0	43,022.9	807.1
	БГАҮТХ-ын зардал	15,600.0	15,568.4	3,631.6
	<b>Нийт зарлагын төсөв</b>	<b>585,289.9</b>	<b>534,574.2</b>	<b>50,715.7</b>
	Үйл ажиллагааны ашиг	-	68,829.2	(68,829.2)
	<b>Нийт дүн</b>	<b>585,289.9</b>	<b>465,745.0</b>	<b>119,544.9</b>

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа <sup>1</sup> илрээгүй, 64,507.0 мянган төгрөгийн зөрчил <sup>2</sup> илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 3 зөрчилтэй асуудал нь 64,507.0 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 4,993.6 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**5.1.1** Тайлант онд 64,507.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн нь сумын ИТХ-ын 2022 оны 17 дугаар тогтоолоор баталсан дүрмийн 5.3 “Газар нь үндсэн хөрөнгийг өмч хариуцсан холбогдох байгууллага, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн олж авах, балансад бүртгэх, хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй”, аймгийн ИТХТ-ийн 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2.1-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд нь батлагдсан төсвийн эх үүсвэр болон ажлын зайлшгүй шаардлагаар хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй эд хөрөнгө худалдан авах саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлж холбогдох шийдвэрийг гаргуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

**5.1.2** Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь хэрэглэгчийн дулааны үнэ тарифыг батлуулаагүй байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Цахилгаан, дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цахилгаан, дулаан худалдах үнэ, нөхцөлийг дор дурдсанаас бусад тохиолдолд Зохицуулах хороогоор хянуулж батлуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

**5.1.3** Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь 2023 оны биенес төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөс батлаагүй. Энэ нь Эрдэнэмандал сумын ИТХ-ын 2022.01.27-ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7-д ТУЗ-ийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлүүлнэ” 6.7.3 “Газрын төсөв, төлөвлөгөө болон ...батлах”, 6.7.6 “Газрын үйл ажиллагааны ажлын тайлан, бизнес төлөвлөгөөний төслийг хэлэлцэн батлах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, зардлыг эдийн засгийн үндэслэлтэй тооцож, хэлэлцэн батлах албан шаардлагыг тус ОНӨААТҮГ-ын ТУЗ-д хүргүүлээ.

### 5.2 Зөвлөмж

#### 5.2.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт: Эрдэнэмандал хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах.*

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн хэрэглэгчийн дулааны үнэ тарифыг батлуулаагүй	1	64507.0			1	64507.0						
2023 оны биенес төлөвлөгөөг төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулаагүй	1	0			1	0						
Нягтлан бдох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй	1	0			1	0						
<b>дүн</b>	<b>4</b>	<b>64507.0</b>			<b>3</b>	<b>64507.0</b>	<b>1</b>	<b>0</b>				
Завсрын аудитаар												
худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүй	1	43000.0							1	43000.0		
авлага, өглөгийн тооцоог 2023 оны 3-р улирлын санхүүгийн тайланд баталгаажуулан тусгаагүй	1	33,551.1			1	33,551.1						
Санхүүгийн тайлангийн Си ти эс программд 2022 оны үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг тусгаагүй, 2023 оны 3-р улирлын тайланд элэгдлийн зардал тооцож бүртгээгүй, эд хариуцагч тус бүрээр хөрөнгийн карт хөтлөөгүй, өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтыг хэрэгжүүлээгүй	1	0			1	0						
<b>дүн</b>	<b>3</b>	<b>76551.1</b>			<b>2</b>	<b>33551.1</b>			<b>1</b>	<b>43000.0</b>		
<b>Нийт дүн</b>	<b>7</b>	<b>141058.1</b>			<b>5</b>	<b>98058.1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>43000.0</b>		

